

ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛ ХҮСЭГЧ ИРГЭДИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- Зээл хүсэгчийн өргөдөл /Хавсралт 1/
- Зээл хүсэгчийн гараар бичсэн өргөдөл / зээлийн хэмжээ, зээлийн хугацаа, зээлийн хүү, орон сууцны зээлд хамрагдах тухай тодорхой заасан байх /
- Гүйцэтгэгч /худалдагч/ болон Зээлдэгч нарын хооронд байгуулсан орон сууц худалдах, худалдан авах, барих, бариулах талаарх гэрээ
- Урьдчилгаа төлбөр төлсөн баримт /байрны үнэлгээний 30% -аас багагүй төлбөр төлсөн байх, эсвэл төлж чадахыг нотолсон байх/
- Урьдчилгаа төлбөрийг хуримтлуулсан хадгаламжийн дансны хуулга, эсвэл холбогдох тодруулга хийсэн байх.
- Зээлдэгч, Зээлдэгчийн гэр бүлийн гишүүд болон хамтран зээлдэгчийн анкет /хавсралт -2 /
- Иргэний болон ажлын газрын үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- тогтмол болон тогтмол бус орлогыг нотлох баримтууд:
 - ✓ Байгууллагын цалингийн тодорхойлолт. / цаашид тогтвор суурьшилтай ажиллах боломжтой эсэхийг тодорхой заасан байх шаардлагатай./
 - ✓ Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар / албан тушаалд томилсон хуудсыг оруулсан байх /
 - ✓ Байгууллагатай байгуулсан хөдөлмөрийн гэрээний эх хувь. / хугацааны сунгалт хийсэн эсэхийг тодруулах /
 - ✓ Бусад /Цалингийн картын хуулга гэх мэт/
- Гэрлэгсдийн гэрчилгээний хуулбар
- Оршин суугаа хорооны ам бүлийн тодорхойлолт / дэлгэрэнгүй-ам бүлийн гишүүдийн нэр, регистрийн дугаартайгаар авна/
- Барьцаа хөрөнгийн талаарх баримт .
- Дансны хуулга / урьдчилгаа төлбөр болон бусад бизнесийн орлогын гүйлгээ хийгддэг данстай бол /
- Банк хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны тодорхойлолт /зээлдэгч гишүүн тус бүр дээр тодорхойлолт авах- 100 айлд байрлах хуучнаар Банкны Өр барагдуулах албанаас авна. /
- Банкнаас шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛ ОЛГОХ ҮНДСЭН ШАЛГУУР.

Зээлдэгч иргэн нь зээл олгох дараахь үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлагатай.

- /1/ Монгол улсын иргэн байх;
- /2/ Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад тогтвортой ажилладаг байх ./Орон сууцны зээлийн өргөдөл гаргахаас өмнө одоогийн ажиллаж буй байгууллагадаа , тухайн салбартаа 1-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан байх/;
- /3/ Бизнесийн орлоготой байх /орон сууцны зээлийн өргөдөл гаргах үеийн бизнесийн үйл ажиллагааг 2-оос доошгүй жил тогтвортой эрхэлсэн байх/;
- /4/ Өрхийн орлогын 45 хүртэл хувиар сар бүрийн зээл хүүгийн төлбөрийг төлөх чадвартай байх;
- /5/ Бусад арилжааны банк болон ББСБ, ХЗХоршоонд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн, зээлийн хүүгийн өр төлбөргүй байх;
- /6/ Худалдан авах орон сууцны үнийн дүнгийн 30-аас доошгүй хувийг төлөх чадвартайг нотлох эсвэл банкинд байршуулсан байх;

Харилцах утас : 315351, 315352

Факс:

Улаанбаатар хотын банк – Орон сууцны зээлийн төв